



Мэргэшсэн ХАБЭА-н Мэргэжилтнүүдийн Холбооны
Удирдах зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 17-ны
өдрийн 04/24 тоот тогтоолын Хавсралт №2

МЭРГЭШСЭН ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙН МЭРГЭЖИЛТНҮҮДИЙН ХОЛБОО ТББ

БАТАЛГААЖУУЛАЛТЫН СХЕМ

**МОНГОЛЫН МЭРГЭШСЭН ХАБЭА (ХЭМАБ)-Н
МЭРГЭЖИЛТЭН (ММХЭМАБМ)**

MOSHRA-БС-01/23.

Хувилбар 2.0

АНХНЫ ХУВИЛБАР

**Улаанбаатар хот
2024 он**

БАТАЛГААЖУУЛАЛТЫН СХЕМ		
Баталсан огноо: 2024.05.17	Баримт бичгийн дугаар МОШПА-БС-01/24	Хувилбар: 2.0
Анхны хэвлэл 2022-02-26		
Эргэж хянах огноо: 2026-05-16		

Баталсан:	Мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүийн холбоо ТББ-ын Удирдах зөвлөлийн 2024 оныдугаар
Боловсруулсан:	МОШПА ТББ-ын Арга зүйн хороо
Хянасан:	Мэргэшсэн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэргэжилтнүүийн холбоо ТББ-ын Гүйцэтгэх захирал
Товч утга /шинээр/	ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо бүхий тогтвортой бизнесийг дэмжих тухай бодлогыг хэрэгжүүлэх хэрэгцээ, хүлээлтийг хангах чадамжтай мэргэжилтнийг баталгаажуулахад оршино.
Хэвлэгдсэн хувь	Нийт 2 хувь: 1 дэх хувь – Хэвлэмэл Эх хувь 2 дахь хувь – Цахим баримт бичгийн нэгдсэн санд

Гарчиг

1-р хэсэг. Монголын Мэргэшсэн ХЭМАБ-ын Мэргэжилтний Баталгаажуулалтын Схемийн танилцуулга	3
1. Танилцуулга	4
2. Монголын ХЭМАБ-ын мэргэшсэн мэргэжилтний баталгаажуулалтын Схем	5
3. Хамрах хүрээ	6
4. Иш татсан баримт бичиг	7
5 Нэр томъёо ба тодорхойлолт	8
2-р хэсэг. Баталгаажуулалт хийлгүүлэх ХЭМАБ-ын ажилтанд тавих шаардлага	10
1. Шаардлага	11
3-р хэсэг. Баталгаажуулалтын үйл явц	12
1. Ерөнхий зүйл	13
2. Нөөц	13
2.1 Ерөнхий шаардлага	13
2.2 Баталгаажуулалтын ажилтанд тавих шаардлага	13
2.3 Ажилтны сургалт	14
2.4 Ажилтны мониторинг, дүн шинжилгээ	14
3. Баталгаажуулах үйл явц	14
4 Лого, тэмдэг хэрэглэх, баталгаажуулалтыг иш татах	15
5. Мэдээлэл, баримтжуулалт	15
6. Хариуцлага	15
4-р хэсэг. Сургалтын шаардлага	16
1. Ерөнхий шаардлага	16
2. Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийг бүртгүүлэх	16
3. Сургалтын төрлүүд	17
4. Сургагч багшид тавих шаардлага	18
Хавсралт 1. Баталгаажуулалтын схемийн зураг	19
Хавсралт 2. Баталгаажуулалтын гэрчилгээний загвар	19

**1-р хэсэг. Монголын Мэргэшсэн ХАБЭА (ХЭМАБ)-н
Мэргэжилтний Баталгаажуулалтын Схемийн танилцуулга**

1. Танилцуулга

Ажилтны чадамжийг баталгаажуулах, харилцан хүлээн зөвшөөрөх аргууд нийгмийн бүхий л салбарт шаардлагатай хэвээр байна. Дэлхий дахинд баталгаажуулагдсан ажилтны чадамжийг олон улсад хүлээн зөвшөөрсөн аргаар үнэлэх, магадлах хяналт хийх, давтан үнэлэх замаар схемийн найдвартай байдлыг хангадаг.

Энэ асуудлыг шийдвэрлэх зорилгоор Олон улсын стандартчиллын байгууллага (ISO)-аас аливаа ажилтныг баталгаажуулах, үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрүүлэхэд хэрэглэж болох MNS ISO/IEC 17024:2014 Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага стандартыг 2013 онд батласныг Монгол Улсын Стандартчилал, хэмжил зүйн газраас 2014 онд орчуулж, баталсан байдаг. Энэхүү стандартад аливаа ажилтныг баталгаажуулахад шаардлагатай ерөнхий шаардлагыг тогтоосон ба тодорхой ажилтныг баталгаажуулахын тулд түүний онцлог чадамж бүхий схемийг боловсруулсан байхыг тус стандартад тодорхойлсон байна.

Иймд, Монголын ХЭМАБ-ын мэргэшсэн мэргэжилтний баталгаажуулалтын энэхүү Схемийг ХЭМАБ-ын мэргэжилтний чадамжийг үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөхүйц түвшинд хүргэх зорилгоор дээрх стандартын дагуу боловсруулав.

ХЭМАБ-ын менежментийн хэрэгцээ, шаардлага ихсэхийн хэрээр ХЭМАБ-ын мэргэшсэн мэргэжилтэнд тавигдах шаардлага өндөрсөж, аж ахуйн нэгж байгууллагын хөгжилд бодит хувь нэмэр оруулахуйц чадамжтай мэргэжилтнийг хөдөлмөрийн зах зээлд нийлүүлэхэд энэхүү Схемийн ашиг тус оршино.

Мэргэжилтний баталгаажуулалт гэдэг бол тохирлын үнэлгээний нэг арга юм. Бүтээгдэхүүн, үйл явц, менежментийн тогтолцооны баталгаажуулалт зэрэг тохирлын үнэлгээний бусад аргуудыг бодвол бодит шалгуурын тусламжтайгаар мэргэжилтний чадамжийг тогтоох шалгалт авах үйл явцыг агуулдагаараа мэргэжилтний баталгаажуулалт ялгаатай.

Шалгалтыг сайн боловсруулж, зохион байгуулснаар Холбоо нь шударга байдлын болон ашиг сонирхлын зөрчлийн эрсдлийг бууруулж чадах хэдий ч олон улсын дээрх стандартад санал болгосон бусад аргуудыг энэхүү Схемд тусгасан.

Энэхүү Схемд мөн, мэргэжилтний баталгаажуулалтыг тууштай, дүйцэхүйц, үнэмшилтэй явуулдаг болохоо нотлодог байх шаардлагыг тодорхойлсон болно.

2. Монголын ХАБЭА (ХЭМАБ)-н Мэргэшсэн мэргэжилтний баталгаажуулалтын схем

2.1 Монголын ХАБЭА (ХЭМАБ)-н мэргэшсэн мэргэжилтэн (цаашид “Мэргэшсэн мэргэжилтэн” гэх)-ий баталгаажуулалтын энэхүү Схем (цаашид “Схем” гэх)-ийн зорилго нь ХЭМАБ-ын менежментийн тогтолцоо бүхий тогтвортой бизнесийг дэмжих тухай бодлогыг хэрэгжүүлэх хэрэгцээ, хүлээлтийг хангах чадамжтай мэргэжилтнийг баталгаажуулахад оршино.

2.2 Энэхүү Схемийн шаардлагыг хангасныг Гэрчилгээгээр илэрхийлнэ.

2.3 Монголын Мэргэшсэн ХАБЭА-н Мэргэжилтнүүдийн Холбоо (цаашид “Холбоо” гэх) нь энэхүү Схемийн эзэмшигч нь байх ба схемийг боловсруулах, хэрэгжүүлэх, хадгалах, сайжруулах үйл явцыг баримтжуулж, хэрэгжүүлж, хөгжүүлэх үүрэгтэй байна.

2.4 Схем эзэмшигч нь энэхүү схемийн өмчлөл болон схемд хамаарах бүх баримт бичгийн зохиогчийн эрхийг хадгална.

2.5 Схемийн энэхүү баримт бичигт схемийн дүрэм, хэрэгжүүлэх журам болон схемийг удирдлагаар хангах үүрэг, хариуцлагыг тогтоосон ба схемийн оролцогч талууд мөрдөж ажиллана.

2.6 Энэхүү схемийн шаардлагыг Монгол Улсын ХАБЭА-н тухай хууль, ХЭМАБ-ын сонирхогч талуудын хэрэгцээ, шаардлагад нийцүүлсэн болно.

2.7 Схем эзэмшигч нь схемд ашиглаж буй баталгаажуулалтын шаардлагыг тодорхойлсон стандарт болон бусад норматив баримт бичигт мониторинг хийнэ.

2.8 Эдгээр баримт бичигт өөрчлөлт оруулах тохиолдолд баталгаажуулалтын байгууллага схемийн өөрчлөлтөд нийцүүлж үйлчлүүлэгч, шаардлагатай бол бусад харилцагчдад мэдээлж, хэрэгжилтийг удирдах (шилжилтийн хугацаа гэх мэт) үйл явцтай байна.

2.9 Схемийн энэхүү баримт бичиг нь дараах 4 хэсгээс бүрдэнэ:

1-р хэсэг: Схемийн танилцуулга

2-р хэсэг: ХЭМАБ-ын мэргэшсэн мэргэжилтний баталгаажуулахад тавих шаардлага

3-р хэсэг: Баталгаажуулалтын үйл явцад хамаарах шаардлага

4-р хэсэг: Сургалтын шаардлага

2.10 Энэхүү Схемийн тухай Монгол Улсын тохирлын үнэлгээний бодлогын асуудал хариуцсан Төрийн захиргааны байгууллага (СХЗГ)-д мэдээлэл хүргүүлнэ.

2.11 Энэхүү Схемийн дагуу баталгаажуулагдсан Монгол Улсын ХАБЭА (ХЭМАБ)-н Мэргэшсэн Мэргэжилтний талаарх мэдээллийг ХАБЭА-н асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага (ХНХЯ) болон ажил олгогчид хүргүүлж, олон нийтэд нээлттэй болгоно.

2.12 Энэхүү Схемийн баримт бичиг нь нийтэд нээлттэй байна.

2.13 Схемийн гүйцэтгэлийг Холбооны Удирдах Зөвлөлд тогтмол болон Холбооны Бүх Гишүүдийн хуралд жил бүр тайлагнана.

3. Хамрах хүрээ

3.1 Энэхүү Схем Монгол Улсын ХАБЭА-н тухай хуулийн 27.2, 27.3 дахь заалтыг хэрэгжүүлэх чадамжийг баталгаажуулах үйл явцад хамаарна.

3.2 Энэхүү Схемд баталгаажуулалтад хамрагдаж, баталгаажуулагдсан ХЭМАБ-ын Мэргэшсэн Мэргэжилтэн (цаашид “Мэргэшсэн Мэргэжилтэн” гэх) болохыг батлуулахыг зорьсон өргөдөл гаргагч/баталгаажуулалт хийлгэсэн мэргэшсэн мэргэжилтэн, түүнийг баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлэх ажилтны дагаж мөрдөх шаардлагыг тогтоосон.

3.3 Энэхүү схемд ХЭМАБ-ын Мэргэшсэн Мэргэжилтний баталгаажуулалтын шаардлага, түүний дагуу үнэлгээ хийж, баталгаажуулж, бүртгэх шаардлагыг тодорхойлсон.

3.4 Энэхүү Схемд сайн дурын баталгаажуулалтын загварыг санал болгосон ба ХАБЭА (ХЭМАБ)-н чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа ажилтнууд хамрагдах боломжтой байна.

4. Иш татсан баримт бичиг

Энэхүү Схемд дараах баримт бичгийг хугацаа заагаагүй иш татав.

- Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль;
- Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай хууль;
- MNS ISO/IEC 17024:2014 Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага;
- ISO/IEC 17000:2020 Тохирлын үнэлгээ-Тайлбар толь ба Ерөнхий зарчим.

5 Нэр томъёо ба тодорхойлолт

Энэхүү Схемд Монгол улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, Эрүүл ахуйн тухай хууль болон MNS ISO/IEC 17024:2014 Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага стандартын нэр томъёо ба тодорхойлолтыг тохируулан ашиглав.

5.1 баталгаажуулалтын үйл явц

ажилтан нь баталгаажуулалтын шаардлага хангасныг тодорхойлох Холбооны үйл ажиллагаанууд, үүнд, өргөдөл хүлээж авах, үнэлэх, гэрчилгээ олгох, магадлан хянах, дахин баталгаажуулах болон, гэрчилгээ, лого, тэмдгийг хэрэглэх тухай баталгаажуулалтын шийдвэр гаргах үйл ажиллагаанууд хамаарна.

5.2 баталгаажуулалтын схем

тодорхой ажлын байр эсвэл ур чадварын ангилалд хамаарах чадамж болон бусад шаардлага

Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17024:2014 стандартын 3.2 дахь заалтаас иш татав

5.3 баталгаажуулалтын шаардлага

баталгаажуулалтын гэрчилгээ олгох эсвэл хадгалах зорилгоор тогтоосон багц шаардлага, үүнд схемийн шаардлага багтана

Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17024:2014 стандартын 3.3 дахь заалтаас иш татав

5.4 схем эзэмшигч

баталгаажуулалтын схемийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцыг хариуцах байгууллага

Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17024:2014 стандартын 3.4 дэх заалтаас иш татав

5.5 гэрчилгээ

тухайн ажилтан нь баталгаажуулалтын шаардлагыг хангасныг илэрхийлж, олон улсын энэхүү стандартын дагуу Холбооноос олгосон баримт бичиг

5.6 чадамж

зорьсон үр дүнд хүрэхэд мэдлэг ба ур чадвараа ашиглах чадвар

Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17024:2014 стандартын 3.6 дахь заалтаас иш татав

5.7 мэргэшил

шаардлагад нийцсэн боловсрол, сургалт, ажлын туршлага

Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17024:2014 стандартын 3.7 дахь заалтаас иш татав

5.8 үнэлгээ

ажилтан нь баталгаажуулалтын схемийн шаардлагыг хангаж буйг үнэлэх үйл явц

5.9 шударга байх

бодит байдлын илэрхийлэл

Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17024:2014 стандартын 3.15 дахь заалтаас иш татав

5.10 эрх тэгш байх

нэр дэвшигч бүр амжилттай баталгаажуулагдахад олгох тэгш боломж

Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17024:2014 стандартын 3.16 дахь заалтаас иш татав

5.11 хүчин төгөлдөр гэж үзэх

баталгаажуулалтын схемд тодорхойлсны дагуу үнэлгээ хийсэн тухай нотолгоо

Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17024:2014 стандартын 3.17 дахь заалтаас иш татав

5.12 үнэмшилтэй байх

өөр өөр цаг хугацаа, байршил, хэлбэр, шалгагчийн авсан шалгалтын оноо нь хоорондоо хэр хэмжээнд нийцтэй байгааг харуулах үзүүлэлт

Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага MNS ISO/IEC 17024:2014 стандартын 3.18 дахь заалтаас иш татав

5.13 зарга

өргөдөл гаргагч, нэр дэвшигч эсвэл Мэргэшсэн Мэргэжилтнээс тэдгээрийн статустай холбоотойгоор Холбооноос гаргасан аливаа шийдвэрийг дахин авч үзэх тухай хүсэлт

5.14 гомдол

хувь хүн эсвэл байгууллагаас Холбооны үйл ажиллагаа эсвэл Мэргэшсэн Мэргэжилтэнд сэтгэл ханамжгүй байгаа тухай Холбоонд гаргасан заргаас өөр мэдээлэл

5.15 тохирлын үнэлгээний итгэмжлэл

эрх бүхий байгууллагаас тохирлын үнэлгээний байгууллага нь тодорхой үйл ажиллагааг гүйцэтгэх мэргэжлийн чадвартайг тогтоож, хүлээн зөвшөөрөх ажиллагаа

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай Монгол Улсын хуулийн 4.1.5

2-р хэсэг. Баталгаажуулалт хийлгүүлэх ХАБЭА (ХЭМАБ)-н ажилтанд тавих шаардлага

1. Шаардлага

1.1 Схемийн энэ хэсэгт Мэргэшсэн Мэргэжилтэнд нэр дэвшигчийн чадамжийн үнэлгээний аргачлалын дагуу баталгаажуулах үйл явцын шаардлагыг тодорхойлсон.

1.2 Мэргэшсэн Мэргэжилтэнд тавих шаардлагыг суурь, тусгай гэж ангилна.

1.3 Өргөдөл гаргагч нь дараах 2 бүлэг суурь шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Монголын Мэргэшсэн ХАБЭА-н Мэргэжилтнүүдийн Холбооны Ажиглагч гишүүн байна.
2. Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан эрх бүхий байгууллагын бүртгэлтэй ХАБЭА-н ажилтан байна.

Тайлбар 1. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны 12 дугаар сарын 06 -ны өдрийн А/173 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт явуулах болон шалгалт авах журам-ын хоёрдугаар хавсралтын ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтны сургалтын хөтөлбөрт амжилттай хамрагдсан байна.

Тайлбар 2. Энэхүү Схемд “ХАБЭА-н ажилтан” гэдэгт ХАБЭА-н асуудал хариуцсан ажилтан, сургагч багш, судлаач ба ХАБЭА (ХЭМАБ)-н чиглэлээр ажил хөдөлмөр эрхэлж байгаа хүнийг ойлгоно.

1.4 Өргөдөл гаргагч нь дараах 4 бүлэг тусгай шаардлагыг хангасан байна:

1. Боловсролын шаардлага: Дипломын болон түүнээс дээш боловсролтой байна.
2. Ажлын туршлага: ХАБЭА-н ажилтнаар 3-аас доошгүй жил ажилласан байна.
3. Сургалтын шаардлага:
 - 3.1. ISO 45001:2018 стандартын модуль сургалтад амжилттай хамрагдсан байна. Үүнд: М1.Танилцуулах, М2.Хэрэгжүүлэх, М3.Дотоод аудитын; Жич: ISO 45001:2018 Тэргүүлэх аудиторын гэрчилгээтэй бол энэ шаардлагыг хангасанд тооцно.
 - 3.2. ISO 31000:2018 Эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх сургалт.
4. Шалгалт:

Шалгалтыг дараахь сэдвийн хүрээнд бие даалт, дасгал ажил, ярилцлага хийх аргаар чадамжийн үнэлгээний баг зохион байгуулна:

 - ХЭМАБ-ын Манлайлал
 - ХЭМАБ-ын эрсдэлийн менежмент
 - Аюултай тохиолдлын судалгаа.

3-р хэсэг. Баталгаажуулалтын үйл явц

1. Ерөнхий зүйл

1.1 Схемийн энэ хэсэгт Мэргэшсэн Мэргэжилтэнд тавих шаардлагыг хангасан байдалд үнэлгээ хийж, баталгаажуулах журмыг олон улсын MNS ISO/IEC 17024:2014 Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага стандартад нийцүүлсэн.

1.2 Энэхүү схемийн дагуу баталгаажуулах үйл явцыг Монгол Улсын Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 15.3 дахь заалтын дагуу итгэмжлэгдэх боломжтой.

2. Нөөц

2.1 Ерөнхий шаардлага

2.1.1 Холбоо нь Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль, MNS ISO/IEC 17024:2014 *Тохирлын үнэлгээ. Ажилтны баталгаажуулалт явуулах байгууллагад тавих ерөнхий шаардлага* стандарт болон энэхүү Схемийн дагуу Мэргэжилтнүүдийн чадамжийг үнэлж, баталгаажуулах үйлчилгээг хэрэгжүүлэх хангалттай нөөцийг бүрдүүлсэн байна.

2.1.2 Холбоо нь баталгаажуулалтын үйл явцад оролцох орон тооны болон гэрээт ажилтан (цаашид “ажилтан” гэх)-ы эрх, үүргийг ажлын байрны тодорхойлолтоор баталж, удирдлагаар хангана.

2.1.3 Холбоо нь ажилтан тус бүрт мэргэшил, сургалт, туршлага, сонирхлын зөрчлийн талаар хувийн хэргийг хөтөлнө.

2.1.4 Холбооны баталгаажуулалтын үйл явцад оролцох ажилтнууд нууцлал, шударга байдал болон сонирхлын зөрчил зэрэг Холбооны дүрмийг мөрдөх үүрэг амлалт бүхий мэдэгдлийг гаргана.

2.1.5 Хэрэв үнэлгээг гүйцэтгэх ажилтан нь нэр дэвшигчтэй сонирхлын зөрчилтэй болох нь үнэлгээний явцад тогтоогдвол Холбоо нь үнэлгээний үйл явцын нууцлал ба шударга байдалд харшлах зүйл гарахаас сэргийлэх арга хэмжээг авч, бүртгэнэ.

2.1.8 Холбоо нь баталгаажуулалтад оролцож байгаа ажилтнуудтай дараах асуудлаар тохиролцож, гэрээгээр баталгаажуулсны үндсэн дээр баталгаажуулалтын үйл ажиллагаанд оролцуулна:

а. Баталгаажуулалт хийлгүүлж байгаа ажилтантай баталгаажуулах үйл явцад хамаарах асуудлаар сонирхлын зөрчлөөс ангид байна. Тухайн ажилтанд сургалт явуулсан бол баталгаажуулах үйл явцад оролцохгүй байна.

б. Өргөдөл гаргагчтай ажил үүргийн хувьд аливаа сонирхлын зөрчилтэй тохиолдолд Холбооны удирдлагад мэдэгдэнэ.

с. Холбооны мэдээллийн нууцлалын бодлогын хүрээнд үйлчлүүлэгчийн мэдээллийг нууцлана.

2.1.9 Гэрээгээр гүйцэтгүүлж байгаа баталгаажуулалтад хамаарах үйлчилгээ (сургалт, шалгалт гэх зэрэг)-ний хариуцлагыг Холбоо хүлээнэ.

2.2 Баталгаажуулалтын ажилтанд тавих шаардлага

2.2.1 Холбоо үнэлгээний үйл явцад оролцох ажилтныг сонгох, сургах, үнэлэх журамтай байна.

2.2.2 Тухайн нэр дэвшигчид сургалт хийх эсвэл шалгалт авахад оролцсон бол баталгаажуулалтын шийдвэр гаргахад оролцохгүй.

2.2.3 Баталгаажуулалтын үйл явцад оролцох ажилтнууд нь дараах шаардлагыг хангасан байна:

2.2.1 Баталгаажуулалтын менежер

- ХАБЭА-н болон тохирлын үнэлгээний хууль, тогтоомж болон энэхүү схемийн шаардлагын талаар мэдлэгтэй байна;
- Ажилтанд үнэлгээ хийх арга зүйн сургалтад хамрагдсан байна.

2.2.2 Үнэлгээний ажилтан.

- ХАБЭА болон тохирлын үнэлгээний хууль, тогтоомж болон энэхүү схемийн шаардлагын талаар мэдлэгтэй байна;
- Мэргэшсэн Мэргэжилтэн байна.
- Ажилтанд үнэлгээ хийх арга зүйн сургалтад хамрагдсан байна.

2.2.3 Шийдвэр гаргах ажилтан

- ХАБЭА болон тохирлын үнэлгээний хууль, тогтоомж болон энэхүү схемийн шаардлагын талаар мэдлэгтэй байна.

2.3 Ажилтны сургалт

Холбоо нь Мэргэшсэн мэргэжилтний баталгаажуулалтыг шударга, чадамжтай, хариуцлагатай гүйцэтгэх чадамжийг бүрдүүлж, хадгалах зорилгоор сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

2.4 Ажилтны мониторинг, дүн шинжилгээ

Холбоо нь баталгаажуулалтын үйл явцад оролцдог ажилтнуудын гүйцэтгэлд мониторинг, дүн шинжилгээ хийж, баримтжуулна.

3. Баталгаажуулах үйл явц

3.1 Энэхүү схемийн 2 дугаар хэсгийн 1.3 дахь шаардлагыг хангасан ажилтан баталгаажуулалтын үйл явцад хамрагдана.

3.2 Баталгаажуулалтын үйл явц нь дараах үе шатуудтай байна:

1. Өргөдөл гаргах
2. Үнэлгээ хийх
3. Шийдвэр гаргах
4. Баталгаажуулалтын дараах

3.3 Баталгаажуулалтын байгууллага нь Баталгаажуулалтын журмын дагуу баталгаажуулалтыг гүйцэтгэнэ.

3.4 Холбоо нь үнэлгээний төлбөрийн нэгж хэмжээг тогтоож, батлана;

3.5 Үнэлгээний хугацааг дараах байдлаар тооцно:

- а) Үнэлгээний нэг өдрийг найман (8) цагаар тооцох байх ба үүнд үдийн цайны завсарлага багтахгүй;
- б) Үнэлгээний хугацааг үнэлгээний ажлын багтаамжид үндэслэн тодорхойлно;
- с) Чадамжийг үнэлэх хугацааг төлөвлөгөө гаргах, тайлан бичих, аялалын хугацаанаас тусд нь тооцно;
- д) Үнэлгээний ажилтны ажиллах хугацаанд ажиглагч, дадлагажигчийн цаг хамаарахгүй;
- е) Мэргэжилтний үнэлгээнд бэлтгэх болон тайлан бичих хугацааг хамтад нь 0.25 үнэлгээ-өдрөөр тооцно.
- ф) Давтан баталгаажуулалт, дүйцүүлэх, магадлах хяналтын хугацаа анхны баталгаажуулалтын үнэлгээний 3/2-той тэнцүү байх ба үүнд төлөвлөх, тайлан бичих (шаардлагатай бол орчуулга хийх), хугацааг нэмж тооцно;
- г) Үнэлгээ хийх нийт хугацааны 70-аас багагүй хувь нь баримт бичигт дүн шинжилгээ хийх, шалгалт авахад ноогдохоор тооцно.

3.6 Анхны баталгаажуулалтыг 2 жилээр, удаах баталгаажуулалтыг 3-5 жилээр тус тус олгоно.

3.7 Холбоо нь ижил төстэй мэргэжлийн байгууллагын баталгаажуулалтын гэрчилгээг энэхүү Схемийн шаардлагад дүйцүүлж болно.

3.8 Энэхүү схемийг гадаад оронд хүлээн зөвшөөрүүлэх үйл ажиллагааг ижил төстэй мэргэжлийн холбоодын хэлэлцээрийн хүрээнд шийдвэрлэнэ.

4 Гэрчилгээ, лого, тэмдэг хэрэглэх, баталгаажуулалтыг иш татах

4.1 Гэрчилгээний загвар, агуулга

4.1.1 Холбоо нь баталгаажуулалтын шийдвэрийг үндэслэн Мэргэшсэн Мэргэжилтний гэрчилгээг хавсралтад өгсөн загварын дагуу хэвлэнэ.

4.1.2 Гэрчилгээг 1 цаасан дээр монгол, англи хэл дээр хэвлэнэ.

4.1.3 Гэрчилгээнд дараах мэдээллийг оруулна:

1. Холбооны лого;
2. Холбоо барих мэдээлэл;
3. Мэргэшсэн Мэргэжилтний овог, нэр;
4. Үндэслэл болгосон баримт бичгийн иш таталт
5. Шийдвэр гаргасан огноо. Схемийн өөрчлөлттэй холбоотой шийдвэрийг шинэчилсэн огноог тавихдаа хүчинтэй хугацаа өөрчлөгдөхгүй;
6. Анхны баталгаажуулалтын огноо;
7. Гэрчилгээ олгосон огноо;
8. Хүчинтэй хугацаа.
9. Гэрчилгээний дугаар

4.2 Баталгаажуулалтын тэмдэг

4.2.1 Мэргэшсэн Мэргэжилтэн нь Холбооноос баталгаажуулсан болохыг илэрхийлсэн тэмдэг хэрэглэх эрхийг гэрээний үндсэн дээр олгоно.

4.2.2 Баталгаажуулалтын тэмдэгийг Холбооны Баталгаажуулалтын тэмдэг хэрэглэх зааврын дагуу хэрэглэх ба иш татна.

5. Мэдээлэл, баримтжуулалт

5.1 Холбоо нь энэхүү Схемийн үйл ажиллагааны явцад бий болсон мэдээлэлтэй харьцах, хадгалах, дамжуулах, нийтэд зарлах, нууцлах бодлогыг тодорхойлж, удирдлагаар хангана.

5.2 Схемийн үйл ажиллагааг хэвийн байлгахад ашиглаж байгаа баримт бичиг, бүртгэлийн хяналтыг тогтоож, хэрэгжүүлнэ.

6. Хариуцлага

6.1 Холбоо нь дүрмийнхээ хүрээнд Схемийн үйл ажиллагаанаас бий болох үр дагаврыг Монгол улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцна.

6.2 Холбоо нь Схемийн шаардлагыг хангаж Мэргэшсэн Мэргэжилтний хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд, аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирол, түүнээс үүсэх хариуцлагыг үүрэхгүй.

6.3 Холбооны баталгаажуулалтын үйл ажиллагаа нь энэхүү Схем болон MNS ISO/IEC 17024:201 стандартад нийцэж байгааг нотлон харуулах бэлэн байдлыг байнга хангана.

6.4 Холбоо нь энэхүү Схемийн дагуу гүйцэтгэсэн баталгаажуулалтын үйл ажиллагааны тайланг Удирдлагын дүн шинжилгээнд хамруулахаар жил бүр Холбооны Удирдах зөвлөлд хүргүүлнэ.

6.5 Холбоо нь Схемийн дагуу баталгаажуулалт хийлгэсэн Мэргэшсэн Мэргэжилтнүүдийн мэдээллийг Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Яаманд тухай бүр хүргүүлнэ.

6.6 Мэргэшсэн Мэргэжилтэн нь энэхүү Схемийн нэр хүндийг хадгалах ба баталгаажуулагдсан статусыг ашигласан байдлын талаарх товч тайланг баталгаажуулалтын гэрчилгээ авсан өдрөөс хойш жил бүр Холбоонд ирүүлнэ.

4-р хэсэг. Сургалтын шаардлага

4.1 Холбоо нь энэхүү Схемийн үйл ажиллагааг тогтвортой байлгах зорилгоор Схемийн талаарх мэдлэгийг олгох, хэрэглэх арга зүйг эзэмшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлнэ.

4.2 Схемийн сургалтанд Холбооны менежментийн баг, Схемд хамрагдаж байгаа мэргэшсэн мэргэжилтнүүд хамрагдана.

4.3 Схемийн сургалтыг Холбооны Ажлын алба зохион байгуулж, бүртгэлийг хөтлөнө.

Хавсралт 1. Баталгаажуулалтын схемийн зураг

Хавсралт 2. Баталгаажуулалтын гэрчилгээний загвар